“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр № 26/45 Улаанбаатар хот

Зээлээр эх үүсвэр татан төвлөрүүлэх, гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4 дэх заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2026 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

(i) Компанийн зүгээс өөрийн зээлийн бүтээгдэхүүнүүдийн цар хүрээг тэлэх, харилцагчдынхаа өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангаж, санхүүгийн зах зээлд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, санхүүгийн байгууллагаас эх үүсвэр татан төвлөрүүлэх үйл ажиллагааг 2023 оноос эхлэн хэрэгжүүлж буйг дурдсугай.

(ii) Компани нь Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (цаашид "ЕСБХБ")-аас нийт 10,000,000 (арван сая) хүртэлх ам.доллартой тэнцэх төгрөгийн үнийн дүн бүхий, барьцаагүй санхүүжилт (цаашид “**Санхүүжилт**” гэх)-ийг Зээлийн гэрээ (цаашид “**Зээлийн гэрээ**” гэх) байгуулах замаар татан төвлөрүүлэх тохиролцоонд хүрсэн болохыг тэмдэглэсүгэй.

(iii) Энэхүү санхүүжилт нь ЕСБХБ-аас Төв Азийн улс орнууд, түүний дотор Монгол Улсад хэрэгжүүлж буй “Залуучуудын бизнес эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн шаардлагыг хангасан, үйл ажиллагааны удирдлагыг бүхэлд нь хариуцдаг эсхүл эцсийн өмчлөгч нь 35 нас хүрээгүй бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгч (“**Залуу бизнес эрхлэгч**”)-дийн санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлж, Компаниас шаардлага хангасан Залуу бизнес эрхлэгчдийг тогтмол санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлж байгаа болохыг дурдсугай.

(iv) ТУЗ нь уг санхүүжилттэй холбоотой Зээлийн гэрээ болон бусад баримт бичгийн төслийг хүлээн авч, тэдгээрийн нөхцөлтэй танилцан хянасан болохыг дурдсугай.

(v) ТУЗ нь энэхүү тогтоолын (ii) болон (iii) дахь хэсэгт дурдсан нөхцөл бүхий Зээлийн гэрээг байгуулах, хэрэгжүүлэх нь Компани болон түүний хөрөнгө оруулагчдын ашиг сонирхолд нийцэж байгаа болохыг тэмдэглэсүгэй.

ИЙМД,

1. Компанийн ТУЗ-өөс ЕСБХБ-аас 5,000,000 (таван сая) ам.доллартой тэнцэх төгрөгийн эхний санхүүжилт (цаашид "Транч А")-ийг татан төвлөрүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Энэхүү санхүүжилтийн хүрээнд Компани нь дараах гэрээ, баримт бичгүүдийг байгуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Уганбаяр)-д зөвшөөрсүгэй. Үүнд:

2.1.Зээлийн гэрээ;
2.2.Мэдээллийн захидал;

2.3. Нийт санхүүжилттэй холбоотой бусад гэрээ, баримт бичгүүд (үүнд Компанийн нэрийн өмнөөс гаргах санхүүжилт олгох хүсэлт, мэдэгдэл, тайлан, баталгаа, маягт, гэрчилгээ зэрэг багтах бөгөөд эдгээрт талуудын хооронд тохиролцсон эсвэл шаардлагатай гэж үзсэн өөрчлөлтүүдийг оруулж болно); болон

2.4. Дээр дурдсан баримт бичгүүдэд оруулах нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулга болон бусад холбогдох баримт бичгүүд

(цаашид хамтад нь "**Гэрээний багц**") багтах бөгөөд эдгээр Гэрээний багц нь зөвхөн Транч А-д бус, санал болгож буй нийт санхүүжилтэд хамаарах болохыг дурдсугай.

3. Гэрээний багцад багтаж буй гэрээ, түүнчлэн эдгээртэй дагалдах бусад гэрээ, хэлцлийг холбогдох талуудтай эцэслэн тохиролцож байгуулах, Гэрээний багцыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тус багцад багтаж буй аливаа гэрээ, хэлцэлд дурдсан зөвшөөрөл, хүсэлт, мэдэгдэл болон үүгээр хязгаарлагдахгүйгээр Компанийн нэрийн өмнөөс үйлдвэл зохих аливаа баримт бичгийг үйлдэх, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулан холбогдох талд хүргүүлэх, хариу хүлээн авах, эдгээртэй холбогдох шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.

4. Зээлийн гэрээ болон түүний нөхцөлийг Хавсралт 1-д заасан хувилбараар баталсугай.

5. Гэрээний багц түүнтэй холбогдуулан үйлдсэн аливаа баримт бичгийн хэрэгжилт, Санхүүжилт татан төвлөрүүлэлт болон ашиглалт, холбогдох бусад мэдээллийг Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

6. Санхүүжилтийн хүрээнд Транч А-аас давсан аливаа санхүүжилт (цаашид "Транч Б")-ийг ашиглах эсвэл түүний дүнг нэмэгдүүлэх тохиолдолд ТУЗ-өөс урьдчилан зөвшөөрөл авсугай.

7. Санхүүжилтийн хөрөнгийг ЕСБХБ-аас санаачилсан "Залуучуудын бизнес эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн зорилгод нийцүүлэн, уг хөтөлбөрийн шалгуурт нийцсэн Залуу бизнес эрхлэгчдийн бизнесийг санхүүжүүлэхэд зарцуулсугай.

8. Энэхүү Тогтоолд өөрөөр тодорхойлоогүй нэр томьёонууд нь Зээлийн гэрээнд заасан утгаар ойлгохыг тодорхойлсугай.

9. Энэхүү Тогтоолыг Монгол, Англи хэл дээр үйлдэх бөгөөд хоёр хувилбарын хооронд зөрүү гарвал Англи хэл дээрх хувилбарыг баримталсугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

Ө.БОЛДБААТАР

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр № 26/46 Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын Репо арилжаанд оролцох эрхийг нэмэгдүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.22, 9.6.23 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 22/12 тоот тогтоол, 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 25/49 тоот тогтоол болон Компанийн ТУЗ-ийн 2026 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн эх үүсвэрийг үр ашигтай удирдах зорилгоор Репо арилжаанд зээлдүүлэгчийн хувиар оролцоход баримтлах арилжааны хэмжээг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тогтоолоор шинэчлэгдсэн батлагдсан арилжааны хэмжээний дагуу Репо арилжаанд оролцох, арилжааны хэмжээ нэмэгдсэнтэй холбогдуулан Компанийн хэвийн зээлийн багцыг нэмэгдүүлсэн хэмжээнээс тооцон нэмж барьцаалах, эдгээр үйл ажиллагааны хүрээнд “Мони Маркет Фанд” ХХК-тай нэмэлт гэрээ, хэлцэл байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.

3. Репо арилжаанд Компанийн эрх ашиг болон дотоод бодлогод нийцүүлэн оновчтой оролцох, үр ашигтай түвшинд удирдан зохион байгуулж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг Компанийн ТУЗ-д тогтмол тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР